



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/15

Дадал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэхь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн

Дарга: (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: (Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч)  
(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

(Цэцэрлэгийн эрхлэгч)

(“Дадал 35” станцын инженер)

(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

(Хэсгийн төлөөлөгч)

(Бэлчээр, газар тариалан асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж, дүрэм журмыг олон нийтэд сурталчлах, таниулах, үнэлэлт дүгнэлт өгөх, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, ажиллагсдад ажлын байран дахь зөв зан үйлийг төлөвшүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг зөвлөлд даалгасугай.

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөлийн ажлын төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэсэн ажил, үр дүнг сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэд, олон нийтэд хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш. МӨНХХУЯГ



010000164